

Агуулга

| | |
|---|----|
| НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА | 2 |
| 1.1. Төслийн талаарх мэдээлэл | 2 |
| 1.2.Төслийн байршил | 2 |
| 1.3. Налайхын чулуун нүүрсний ордын баруун жигүүрт ногдох нөөцийн тооцооны талаар | 3 |
| Гадаад зам | 10 |
| Физик газарзүй | 11 |
| Налайхын бүс нутгийн эдийн засгийн байдал | 11 |
| Зам харилцаа..... | 12 |
| Уурхайн ерөнхий байдал | 13 |
| ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ | 14 |
| ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ | 15 |
| ДҮГНЭЛТ | 24 |

НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн талаарх мэдээлэл

Хүснэгт №1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

| № | Үзүүлэлтүүд | |
|----|--------------------------------------|--------------------|
| 1 | Аж ахуйн нэгжийн нэр | |
| 2 | Улсын бүртгэлийн дугаар | |
| 3 | Уурхайн нэр | |
| 4 | Ордын байршил | Нийслэл/Хот/ Аймаг |
| 5 | | Сум/Дүүрэг |
| 6 | Ашигт малтмалын төрөл | |
| 7 | Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар | |
| 8 | Аж ахуйн нэгжийн хаяг | Аймаг/Хот |
| 9 | | Сум/Дүүрэг |
| 10 | | Баг/Хороо |
| 11 | Захирлын хаяг | Нэр |
| 12 | | Гар утас |


1.2.Төслийн байршил

“Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт, Улаанбаатар хотын төвөөс 45км, Налайх дүүргийн төвөөс 3км зайд байрлана. Нийт 198.84 га талбайтай.

Хүснэгт №2. MV-000221 тоот талбайн солбилцол

| Д/д | Уртраг | | | Өргөрөг | | |
|-----|--------|-----|-------|---------|-----|-------|
| | град | мин | сек | град | мин | сек |
| 1 | 107 | 14 | 45.52 | 47 | 44 | 56.37 |
| 2 | 107 | 14 | 50.79 | 47 | 44 | 56.26 |
| 3 | 107 | 14 | 50.53 | 47 | 44 | 50.11 |
| 4 | 107 | 15 | 0.12 | 47 | 44 | 49.93 |
| 5 | 107 | 14 | 59.88 | 47 | 44 | 44.43 |
| 6 | 107 | 15 | 9 | 47 | 44 | 39.72 |
| 7 | 107 | 15 | 8.8 | 47 | 44 | 39.72 |
| 8 | 107 | 15 | 16.96 | 47 | 44 | 39.56 |
| 9 | 107 | 15 | 16.8 | 47 | 44 | 36 |
| 10 | 107 | 15 | 29.75 | 47 | 44 | 35.74 |
| 11 | 107 | 15 | 29.91 | 47 | 44 | 39.3 |
| 12 | 107 | 15 | 35.18 | 47 | 44 | 39.2 |
| 13 | 107 | 15 | 35.51 | 47 | 44 | 46.8 |
| 14 | 107 | 15 | 42.23 | 47 | 44 | 46.67 |
| 15 | 107 | 15 | 42.6 | 47 | 44 | 55.24 |
| 16 | 107 | 15 | 49.8 | 47 | 44 | 55.1 |
| 17 | 107 | 15 | 50.17 | 47 | 45 | 3.84 |
| 18 | 107 | 15 | 55.93 | 47 | 45 | 3.72 |
| 19 | 107 | 15 | 56.25 | 47 | 45 | 11.16 |
| 20 | 107 | 16 | 3.93 | 47 | 45 | 11.01 |
| 21 | 107 | 16 | 4.27 | 47 | 45 | 18.78 |
| 22 | 107 | 16 | 11.22 | 47 | 45 | 18.64 |
| 23 | 107 | 16 | 11.63 | 47 | 45 | 28.02 |
| 24 | 107 | 16 | 1.33 | 47 | 45 | 28.23 |
| 25 | 107 | 16 | 1.46 | 47 | 45 | 31.46 |
| 26 | 107 | 15 | 49.94 | 47 | 45 | 31.69 |
| 27 | 107 | 15 | 50.06 | 47 | 45 | 34.28 |
| 28 | 107 | 15 | 40.46 | 47 | 45 | 34.47 |
| 29 | 107 | 15 | 40.68 | 47 | 45 | 39.64 |

| | | | | | | |
|----|-----|----|-------|----|----|-------|
| 30 | 107 | 15 | 24.85 | 47 | 45 | 39.95 |
| 31 | 107 | 15 | 24.64 | 47 | 45 | 35.1 |
| 32 | 107 | 15 | 18.4 | 47 | 45 | 35.22 |
| 33 | 107 | 15 | 18.06 | 47 | 45 | 27.3 |
| 34 | 107 | 15 | 16.37 | 47 | 45 | 27.33 |
| 35 | 107 | 15 | 16.37 | 47 | 45 | 26.77 |
| 36 | 107 | 15 | 19.37 | 47 | 45 | 26.77 |
| 37 | 107 | 15 | 19.37 | 47 | 45 | 25.77 |
| 38 | 107 | 15 | 11.37 | 47 | 45 | 25.77 |
| 39 | 107 | 15 | 11.37 | 47 | 45 | 27.43 |
| 40 | 107 | 15 | 10.86 | 47 | 45 | 27.44 |
| 41 | 107 | 15 | 10.63 | 47 | 45 | 22.1 |
| 42 | 107 | 15 | 4.88 | 47 | 45 | 22.21 |
| 43 | 107 | 15 | 4.67 | 47 | 45 | 17.36 |
| 44 | 107 | 15 | 0.11 | 47 | 45 | 17.45 |
| 45 | 107 | 14 | 59.89 | 47 | 45 | 12.27 |
| 46 | 107 | 14 | 51.49 | 47 | 45 | 12.44 |
| 47 | 107 | 14 | 51.17 | 47 | 45 | 5 |
| 48 | 107 | 14 | 45.89 | 47 | 45 | 5.1 |



Зураг №1. Төслийн талбайн байршилн зураг

1.3. Налайхын чулуун нүүрсний ордын баруун жигүүрт ногдох нөөцийн тооцооны талаар

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Налайхын нүүрсний ордын баруун жигүүр нэртэй 199.54 га талбай бүхий MV-000221 тоот тусгай зөвшөөрлийг АМХЭГ-аас 1996 оны 10 дугаар сарын 28-ны өдөр олгосон бөгөөд 2013 оны 7-р сарын 18-ны өдрийн 310 тоот шийдвэрээр “Сүмбэр худаг” ХХК-д шилжүүлснийг бүртгэсэн байна.

MV-000221 тоот тусгай зөвшөөрлийн талбайн булангийн 42 солбицлын цэгүүдийг АМГ-ын даргын 2010 оны 127 тоот тушаалаар WGS-84 тогтолцоонд албан ёсоор оруулсан ба ГУУКХ -ийн

даргын 2010 оны 341 тоот шийдвэрээр булангийн цэгүүдэд өөрчлөлт оруулж солбилшлын цэгтэй болгосон байна. Тус тусгай зөвшөөрлийн талбайд ноогдох нөөцийн тодотгол тооцоог энэ WGS84 системийн 48 солбилшлын хэмжигдэхүүнээр тодорхойлогдсон талбайд гүйцэтгэсэн байна.

Налайхын нүүрсний ордын баруун жигүүр нь Налайхын нүүрсний ордын баруун хэсэгт хайгуулын шугам IV-VIII хооронд агуулагдах бөгөөд хойгуураа нүүрсний V давхраасын гаршийг багтааж түүнийг дагасан тусгай зөвшөөрлийн 20-28 дугаартай зиг заг шугам, зүүн талаараа хайгуулын VIII шугамыг багтааж, түүнийг дагасан 28-40 дугаартай зиг заг шугам, урд талаараа техникийн хилийг дагасан 40-48 дугаартай зиг заг шугам, баруун талаараа хайгуулын IV шугам буюу 2-р хагарлыг дагасан 1-20 дугаартай зиг заг шугамаар хүрээлэгдэж байгаа олон өнцөгт болно.

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Налайх дүүргийн ордын баруун жигүүрийн хэсэгт 2013онд гүйцэтгэсэн нөөцийн тодотгол тооцооны тайлан” Ордын нөөц 2014 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар) дахь Налайх нүүрсний уурхайн баруун жигүүр нэртэй MV-000221 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах эдийн засгийн үр ашигтай баттай, бодитой болон боломжтой (A+B+C) цэвэр нүүрсний нөөцийг 25,429.46 мян.тн-оор, чулууны үеийн нүүрсний нөөцийг 27,806.69 мян.тн-оор үүнээс эдийн засгийн үр ашиг баттай, бодитой болон боломжтой (A+B+C) цэвэр нүүрсний нөөцийг 22,002.29 мян.тн-оор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 24,203.66 мян.тн-оор, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай бодитой болон боломжтой (B+C) цэвэр нүүрсний нөөцийг 3,427.16 мян.тн-оор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 3,603.03 мян.тн-оор хүлээж авсан.





Зураг №2. Өнөөгийн төлөв байдлын зураг

Нөөцийн тодотгол тооцоонд тооцооны жишиг үзүүлэлтийг

1. Нүүрсний үе давхраасын олборлолтын хамгийн бага зузаан 0,7 м
2. Нүүрсний үеүдэд агуулагдах чулуулгийн үеийн бохирдлыг тооцсон нүүрсний хамгийн их үнсжилт 45%
3. Нүүрсний давхраасын нөөцийг үеэр ангилж бодох, нүүрсний бохирдолтод тооцохгүйгээр ашиглалтын үед ялгаж хаях, чулуулгийн үеийн хамгийн бага зузаан нь 0.8м.
4. Нүүрсний үеийн бохирдлыг тооцохдоо түүнд агуулагдаж байгаа 0.8 м-ээс бага зузаантай чулуулгийн үе йг 100% оруулан тооцно.и

Нөөцийн зэрэг, үнэлгээ

Налайхын нүүрсний орд нь бүтцийн ангиллаар 2-р бүлгийн ордод хамаарагдах, нүүрсний давхраасуудын бүтцээрээ нийлмэл, зузааны тогтворжилтоор муу, тектоник хагарлаар нилээд хэрчигдсэн орд юм.

Нүүрсний “шинэ” 0, I, II, “Завсрын”, YIII давхраасууд нь үеийн зузааны хэлбэлзэл, түүний бүтцээрээ тогтворжилт муутай давхраасад ангилагдах ба III, IV, V давхраасууд нь нийлмэл, маш нийлмэл бүтэцтэй, зузааны хэлбэлзлээр харьцангуй тогтвортойд тооцогдоно.

Налайхын ордын нөөцийг А, В, С зэргээр тооцоолов. Нөөцийн А зэргээр нүүрсний чанар болон нүүрсний давхраасуудын тогтоц нарийвчлан судлагдсан, тектоникийн нэг блокийн хэмжээнд тархалттай хайгуулын торын 100-250-300 м-ийн нягтралтай, ашиглалтын малталтуудаас шууд залган тархсан талбайн нөөцийг бодлоо.

Нөөцийн В зэргээр, нүүрсний давхраасын тогтоц, нүүрсний чанар геологи хайгуулын цооногуудаар болон ашиглалтын малталтаар хангалттай судлагдсан бөгөөд хайгуулын торыг 150-300x250-350 метрийн нягтралтайгаар ордын талбайн нөөцийг тооцоолсон болно.

Нөөцийн С зэргээр давхраасуудын бүтэц, нүүрсний чанар харьцангуй муу судлагдсан. А, В нөөцийн талбайн үргэлжлэл, жишгийн изо-шугамаар хязгаарлагдах талбайн нөөцийг бодов.

Налайхын нүүрсний ордын баруун жигүүрт нүүрсний давхраасууд тархсан байдал тэдгээрийн үнэлэмжийн талаар цухас дурдвал: Үүнд:

Нөөцийн тодотгол тооцооны аргачлал ба үр дүн

Нөөцийн тодотгол тооцоог эдийн засгийн үр ашигтай нөөц ба тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай нөөц, уурхайн техникийн хилийн гадна ба дотор, мөн зузаанаар нь >3.0 м, 1.2-3.0 м, 0.7-1.2 м, <0.7 м гэх мэт хуучин янзаар нь ангилан ялгаж бодсон.

1991 оны гүйцээх хайгуулын ажлаар Налайхын ордод тооцоологдсон А зэргийн нөөц бүгд MV-000221 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд тооцоологдсон тул үлдсэн талбайд А зэргийн нөөц байхгүй болно. MV-000221 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд гүйцэтгэсэн тодотгол тооцоогоор баттай А нөөц 4736,49 мянган тонн болж 216,29 мянган тонноор нэмэгдсэн нь AUTOCAD программаар хэмжсэн талбай өссөнтэй холбоотой. Одоо Налайхын ордод үлдэж байгаа нөөц 1991 оны гүйцээх хайгуулын ажлын үр дүнгээр тооцоологдсон нөөц тул нөөцийн зэрэглэлийг хуучнаар нь үлдээсэн байна.

Хүснэгт №3. Нийт нөөц бодсон талбайн хэмжээнд дэх нөөцийн нэгдсэн хүснэгт 2014 оны 2 аар сард батлагдсан байдлаар / Тусгай зөвшөөрлийн хилийн дотор/

| Нөөцийн ангилал | Нийт нөөц /мянган.т/ | | Үүнээс /мянган.т/ | | | | | |
|--|----------------------|------------------|-------------------|------------------|-----------------|------------------|----------------|------------------|
| | Цэвэр | Бохирдол тооцсон | А | | В | | С | |
| | | | Цэвэр | Бохирдол тооцсон | Цэвэр | Бохирдол тооцсон | Цэвэр | Бохирдол тооцсон |
| Эдийн засгийн үр ашигтай нөөц | 22002,29 | 24203,66 | 4736,49 | 5324,93 | 10235,29 | 11367,66 | 7030,51 | 7511,07 |
| Тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай нөөц | 3427,16 | 3603,03 | - | - | 688,67 | 717,13 | 2738,49 | 2885,9 |
| Нийт | 25429,46 | 27806,69 | 4736,49 | 5324,93 | 10923,98 | 12084,79 | 9769,00 | 10396,97 |

Далд уурхайн олборлолт

Газрын гадаргуугийн хэлбэр болон топограф

Уурхайн районы газрын гадаргуу ерөнхийдөө тэгш боловч хойд талын хэсэгтээ өндөр, төмөр замын ойролцоо өмнө талын хэсэгт нам байдаг. Анхны уурхайн хойд хэсэгт хамгийн өндөр болон нам цэгүүдийн өндөржилтийн ялгавар 90 метр орчим байна. Уурхайн байгаа газар нь гуу жалга бүхий толгодорхуу газар бөгөөд өндөржилт нь 1450-1550 метрт хэлбэлзэнэ.

Уул геологийн нөхцөл

Ордын уул геологийн нөхцөлд үндэслэн уурхай байгуулах үе шатан дахь үйлдвэрлэлийг эхлэх хугацаа, уурхайн барилга байгууламжийн ажлын хэмжээг тодорхойлох, эдийн засгийн үр өгөөжийг тооцох ач холбогдолтой. Ордын геологийн тогтоц ба гидрогеологийн нөхцөл харьцангуй энгийн буюу дунд зэргийн хүндрэлтэй гэж үзэж байна.

Нүүрсний давхаргын нөхцөл

Уурхайн талбайд ашиглах боломжтой II, III, IV, V давхаргууд нь дунд зэргийн болон зузаан давхаргууд бөгөөд 5-18⁰-ийн уналтай. VIII давхарга нь 1.25 метрийн зузаантай нимгэн давхарга бөгөөд уналын өнцгийн хувьд 15⁰ юм. Уурхайн районд 3 ил хагарал байгаа нь геологийн тогтоц болон уурхайн олборлолтод төдийлөн нөлөө үзүүлэхгүй. Нүүрсний давхаргын ул, тааз нь элсэрхэг чулуу, элсэн чулуу зэргээс бүрдэнэ.

4.3 Уурхайн ажлын горим

Уурхай жилд 347 хоног ажиллахаар ТЭЗҮ-д тусгагдсан. Ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг бөгөөд хоногт 3 ээлж ажиллана.

Хүснэгт №4. Ээлжийн үргэлжлэх хугацаа

| № | Ээлжийн үргэлжлэх хугацаа | | Далд уурхайд | Газрын дээр |
|---|------------------------------------|-------|--------------|-------------|
| 1 | Календарь хоног | хоног | 365 | |
| 2 | Баяр ёслол | хоног | 11 | |
| 3 | Цаг агаараас хамаарсан сул зогсолт | хоног | 7 | 7 |
| 4 | Уурхайн цэвэр ажлын хоног | хоног | 347 | 347 |
| 5 | Хоногийн ээлжийн тоо | - | 8 | 2 |
| 6 | Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 3 | 8 |
| 7 | Ээлжийн цаг ашиглалтын коэффициент | - | 0.8 | 0.8 |
| 8 | Уурхайн хоногт ажиллах бодит цаг | цаг | 7.2 | 7.2 |
| 9 | Уурхайн жилд ажиллах бодит цаг | цаг | 5335.2 | 533.2 |

4.3.1 Нэвтрэлтийн ажлын зохион байгуулалт

Өрөмдөх, тэслэх, агааржуулах, ухаж, ачих, бэхлэх гэх мэт нэвтрэлтийн ажлын үйл явцуудыг нэг ээлжид багтаан ажиллах нь бага хөндлөн огтлолтой малталтын хувьд зохион байгуулалтыг ягштал биелүүлэх боломж тэр бүр байдаггүй. Харин томоохон хөндлөн огтлолын талбайтай үед нэгэн зэрэг ажлууд явагдах болон механикжсан техникүүдийг хэрэглэх боломжуудтай тул нэвтрэлтийн ажил нь жигд явцтай байдаг. Чулуун нүүрсний уурхайд ихэвчлэн хэрэглэгддэг ажлын горимын жишээгээр:

- Өрөмдлөг, тэсэлгээний ажил
- Чулуулгийг ухаж, ачих
- Малталтын тааз болон мөргөцгийн ханыг цэвэрлэх
- Таазыг бэхлэх
- Мөргөцгийг бэхлэх

4.4 Ашиглалтын системийн сонголт, уурхайн хүчин чадал

4.4.1 Ордын геологийн нөөц болон нүүрсний давхаргуудын тогтоц

Налайхын уурхайн техникийн хил дотор Баруун жигүүрийн 221А тоот лицензтэй талбайд 1993 онд хийгдсэн гүйцээх хайгуулаар геологийн тэнцлийн нөөц 23409.22 мянган тонн үлдсэн байгаа болно. Налайхын уурхайн чулуун нүүрсний давхаргууд нь сунаж тогтсон, хэвтээ болон хэвгий уналтай, геологийн гажилт багатай юм. II, III, IV, V нүүрсний давхаргууд нь 1,3 - 4,4 м хүртэл зузаан, суналын дагуу 1 км орчим үргэлжлэх бөгөөд 5- 180 уналтай оршино. VIII нүүрсний давхаргын тогтоц мөн үүнтэй төстэй бөгөөд ойролцоогоор 300 м орчим гүнд уналын дагуу 1,3 км үргэлжилнэ.


4.4.2 Ашиглалтын системийн сонголт

Ашиглалтын системийн сонголтод геологийн нөөц болон эдийн засгийн үзүүлэлтүүдээс гадна тухайн ордын байгалийн тогтоц болох ашигт малтмалын зузаан, сунал ба уналын дагуух урт, тэдгээрийн налуугийн өнцөг, ашигт малтмалын болон хажуугийн чулуулгийн тогтворжилт, ашигт лалт явуулах гүн зэрэг нь чухал үүрэгтэй.

Налайхын далд уурхайн чулуун нүүрсний давхаргуудыг олборлоход түүний геологийн тогтоц, ашигт малтмалын нөөцөөс хамааруулан ордыг бүрэн дүүрэн олборлох боломж бүхий далд уурхайн туушид мөргөцгөөр (Лааваар) нураан олборлох ашиглалтын систем хэрэглэхээр ТЭЗҮ-д тусгасан.


4.4.2.1 Тууш мөргөцгийн ашиглалтын систем

Хэвгий уналтай орд газруудад ашиглалт явуулахаас өмнө нэвтэрсэн малталтуудыг харгалзан урагш ахих, ухрах эсвэл нийлмэл урагш ахих ба ухрах ашиглалт явагдах эсэхийг шийднэ. Уналын дагуух нүүрсний фронт ба суналын дагуух ашиглалтын штрекүүд бүхий тууш мөргөцгийн ашиглалт нь хэвтээ болон бага зэргийн налуу байрлах нүүрсний мдавхаргад өргөн хэрэглэгдэнэ.



Зураг №3. Тууш мөргөцгийн ухрах ашиглалтын зарчим

Ухрах ашиглалтын үед олборлолтыг дагасан штрекүүд нь түрүүлж нэвтрэх ба үүгээр туушид мөргөцгийн үйлдвэрлэл сааталгүй, түүгээр ч үл барам геологийн эвдрэлүүд нь судлагдсан байна. Хэрвээ ухрах ашиглалтын штрекүүд нь зөвхөн нэг удаа ашиглагдах бол, түүнийг туушид мөргөцгийн ард нураан үлдээж болно.



Зураг №4. Тууш мөргөцгийн ухрах ашиглалтын зарчим

4.4.3 Уурхайн төслийн хүчин чадал

Тууш мөргөцгөөр нүүрсний давхаргыг бүрэн дүүрэн олборлоно. Нүүрсний олборлолтын мөргөцгийг уурхайн техникийн хилээс эхэлж уурхайн ам чиглэлд дараалан ашиглана. Техникийн хилээс эхлэхдээ хуучин ашиглалт явагдсан талбайг нүүрсний цулаар хамгаалан үлдээнэ. Үүнд бэлтгэл малталтаар хамгаалалтын цулыг огтолож ашиглагдсан талбайг агаар, хий оруулах нөхцөлтэй болгохыг хориглоно. Мөн өөрөө шатах чанартай нүүрсийг ашиглаж байгаа бүх уурхайд ашиглагдсан орон зайгаар агаарыг сорох нөхцөлгүй байлгахгаар агааржуулна.

Үйлдвэрлэлийн хүчин чадал нь 670 мянган тонн/жил бөгөөд нэвтрэлтээс дагалдан гарах нүүрсний хэмжээ үүний 4,1 % -тай тэнцүү буюу 257758 мянган тонн/жил байна. Ийнхүү уурхай жилдээ ойролцоогоор 700 мянган тонн нүүрс олборлож, мөргөцгөөс гаргах боломжтой.

4.4.4 Уурхайн ашиглалтын хугацаа

Уурхайн үйлдвэрлэлийн хүчин чадлыг 670 мянган тонн/жил, нөөц бууралтын коэффициент 1 гэж тооцвол төслийн дагуух уурхайн ашиглалтын хугацаа 22 жил болно.

Хүснэгт №5. Олборлох нүүрсний хэмжээ, давхарга тус бүрээр

| Тууш мөргөцгөөр ашиглах нүүрсний давхаргууд | Олборлох нүүрсний хэмжээ |
|---|--------------------------|
| II давхаргын нүүрс олборлолтын хэмжээ | 2834,3 мян.тонн |

| | |
|---|-----------------------|
| III давхаргын нүүрс олборлолтын хэмжээ | 2109,4 мян.тонн |
| IV давхаргын нүүрс олборлолтын хэмжээ | 3611,4 мян.тонн |
| V давхаргын нүүрс олборлолтын хэмжээ | 4734,9 мян.тонн |
| VIII давхаргын нүүрс олборлолтын хэмжээ | 1420.7 мян.тонн |
| Нийт | Нийт 14710.6 мян.тонн |

4.4.5 Тоног төхөөрөмж

Хүснэгт №6. Налуу ам 1 ба 2-ын малталт нэвтрэлтийн ажилд хэрэглэгдэх машин, тоног төхөөрөмж

| Тоног төхөөрөмж | Нэгж |
|---|------|
| 1. NSU, нэвтрэлтийн өрмийн машин | 4 ш |
| 2. Sandvik Th315 (7,5 м3), тээврийн машин | 4 ш |
| 3. Hägglöader 7HR and 7HR-B, ухаж ачих машин | 4 ш |
| 4. Normet Spraymec 1050 WPC HD, шүршмэл бетоны машин | 1 ш |
| 5. Schwing SP4800 Concrete pump, бетон зуурмагийн машин | 1 ш |
| 6. Ingersoll Rand 1550SE Mechanics Service Truck, механик засвар үйлчилгээний машин | 1 ш |
| 7. Atlas Copco GA355 Portable compressor, зөөврийн компрессор | 1 ш |
| 8. Тусгай агааржуулалтын сэнс, хоолой | 2 ш |



ухаж, ачих машин - NSU 1E – P1



Sandvik Th315 маркийн автосамосвол



Hägglöader 7HR and 7HR-B маркийн ачигч машин



Hägglöader 7HR and 7HR-B маркийн ачигч машин



Normet Spraymec 1050 WPC HD, шүршмэл бетоны машин



NSU машин

Зураг 26. Налуу ам 1 болон 2 -ын нэвтрэлтийн ажилд хэрэглэгдэх машин, тоног төхөөрөмж

| | |
|---|--|
|  |  |
| <p>(Coal shearer MB 630 E)</p> | <p>Завсрын буулгах төхөөрөмж</p> |
|  |  |
| <p>Тууш мөргөцгийн олборлолтын гинжит конвейер</p> | <p>Хэвтээ болон налуу малталтуудыг нэвтрэх нэвтрэлтийн комбайн</p> |

Зураг №5. Уурхайн нүүрс олборлолтод ажиллах тоног төхөөрөмж

Гадаад зам

Гадаад зам, уурхайн талбайд хүрэх зам:

Налайхаас Улаанбаатар хүртэл 45км урттай II зэргийн засмал зам байдаг. Зам нь уурхайн талбайгаас ойролцоо өнгөрдөг. Иймээс, уурхайн талбайгаас гол зам хүртэл 0.68км урттай IV зэргийн сайжруулсан зам барих шаардлагатай. Дотоод тээврийн чиглэл нь зүүн-урдаас баруун-хойш чиглэлтэй байна.

Өндөржилт нь: хамгийн их 1480м, хамгийн бага 1485.5м байна. Замын ихэнх хэсэг нь 1485.5 м түвшинд байрлана. Дотоод тээврийн зам нь шавран барьцалдуулагчтай хайрган зам, урт нь 1300 м, өргөн нь 5м, хамгийн их налуу нь 8.5%, эргэлтийн хамгийн бага радиус нь 15м.

Төмөр зам: Монголын төмөр зам уурхайн үйлдвэрлэлийн талбайгаас 300 м зайд өнгөрдөг. Уурхайн талбайгаас 800 м зайд салаа төмөр зам барьж үндсэн замтай холбох шаардлагатай. Ингэснээр, нүүрсийг төмөр замаар аль ч чиглэлд тээвэрлэх боломжтой болно.

Тэсрэх материалын агуулах хүртэлх зам:Тэсрэх материалын агуулах нь уурхайн үйлдвэрлэлийн талбайгаас зүүн-урд чиглэлд байрлана. Ойролцоогоор 0.12 км урттай 5м өргөнтэй IV зэргийн сайжруулсан зам барьж агуулах, уурхайн талбай хоёрыг хооронд нь холбоно.

ХОЁР.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүй

Налайхын уурхай нь Налайхын сав газрын баруун хэсэгт оршино. Энэ сав газар 17-20 км урт, 10-12 км өргөн 200 км² талбайтай уулархаг нам газар юм. Сав газрын хойд хэсэг нь нарийн боловч урт уулархаг нуруутай. Энэ нь 1883,3м өндөржилттэй Баян Хөхийн өндөрлөгийг бий болгоно. Энэ өндөрлөг Налайхын сав газар болон Туул голын зааг юм. Уулархаг нуруу нь мердианы чиглэлийн олон хөндийнүүдэд хуваагдана. Энэ хөндийнүүдээс Туул голын хөндий рүү гадаргуугийн ус орж ирнэ. Сав газрын баруун хэсэг нь мердианы чиглэлийн налуу толгод бөгөөд өмнө талдаа Баян-Уултай, хойд талдаа Баян Хөхийн уултай холбогдоно. Налайхын сав газрын өмнө хэсэг нь Богд уулын салбар бөгөөд хамгийн өндөр цэг нь 1704,7 м юм. Баян-Уулын өндөржилт нь 1717,5 м хүрнэ. Сав газрын зүүн хэсэгт Баян-Уул Туулын уулархаг систем байрлана. Сав газрын ёроолын гадаргуу нь бага зэргийн хотгор гүдгэр бүхий нам газар бөгөөд өндөржилт нь 1410-1500 метрт хэлбэлзэнэ. Сав газрын зах хязгаараар олон тооны дов толгод байх бөгөөд тэдгээр нь уул нуруу болон шилжинэ. Уурхайн байгаа газар нь гуу жалга бүхий толгодорхуу газар бөгөөд өндөржилт нь 1450-1550 метрт хэлбэлзэнэ.

Гол горхи

Налайхын сав газрын төв хэсэгт Налайхын гол өмнөөс хойд зүгт урсана. Тэрчлэн сав газрын зүүн хэсэгт уулархаг уулын гол бий. Энэхүү уулын голууд 1-2 метрийн гүнтэй. Борооны дараа эдгээр голууд усаар дүүрч тэр нь Туул голд цутгана.

Цаг уур, газар хөдлөл

Тухайн район эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд өдрийн туршид ч температурын хэлбэлзэл их байдаг. Зун нь богино, халуун байдаг бол өвөл нь хүйтэн сэрүүн, цас бага унадаг. Жилийн дундаж температур нь -2,1:-4,6⁰C. Жилийн хамгийн хүйтэн сарууд нь 11, 1-р сар болно.

11 сарын дундаж температур нь -21,6⁰C байдаг бол 1-р сарын дундаж температур нь -23,8⁰C байдаг. Жилийн нийт хоногийн 238 орчим нь хүйтэн өдрүүд байна. Эхний хүйтэн өдрүүд 9 сараас эхэлж 5-р сарын эцэс хүртэл үргэлжилнэ. 1-р сарын хамгийн бага температур -48⁰C хүрдэг бол хамгийн халуун нь 7-р сар бөгөөд дээд тал нь +35⁰C хүртэл хална. 7-р сарын дундаж температур 17,1⁰C. Дулааны улиралд ч гэсэн өдрийн туршид температурын ялгаа их байдаг. Өвөл удаан үргэлжилнэ. Өвөлдөө хүйтэн боловч цас унах нь бага, зарим өдрүүд тогтуун байдаг. Энд жилдээ 200-220мм тунадас унах ба хур тунадасны ихэнх нь зуны улиралд орно. Агаарын даралт жилийн 4 улиралд ихээхэн өөрчлөгдөх ба өвлийн улиралд даралт хамгийн өндөр, зуны улиралд хамгийн бага байдаг. Эндхийн цаг уурын нэг онцлог нь агаарын чийглэг бага, хуурай байдаг явдал юм. Сарын дундаж харьцангуй чийглэг 51-68 % -д хэлбэлздэг бол абсолют чийглэг 4-9.4мм байна. Энэ бүс нутагт салхитай байх нь элбэг. Салхины чиглэл ихэнхдээ баруун хойноос, зарим тохиолдолд баруунаас зүүн тийш чиглэсэн байдаг. Салхины дундаж хурд 5-6м/с боловч Налайх хотод салхины хурд 17м/с хүрч байв. Одоо байгаа зарим мэдээллээр газар хөдлөлийн чичирхийллийн эрчимжилт 6 балл бөгөөд ТЭЗҮ-д 6 балл гэж авч үзэж болох юм.

Налайхын бүс нутгийн эдийн засгийн байдал

Налайхын дүүрэг нь хүн ам нэлээн шигүү суурьшсан бүсэд хамаарах ба хүн амын ихэнх нь халхчууд, мөн казах, дөрвөд зэрэг ястнууд байдаг. Энэ бүс нутагт харилцаа холбоо, эмнэлэг, сургууль, уул уурхайн аврах анги, соёлын ордон зэрэг байгууллагууд бий. Мал аж ахуй нь эдийн засгийн гол хэсэг бөгөөд зарим нүүрсний уурхай, тоосгоны үйлдвэр, гар болон механик ажиллагаатай засварын газар зэрэг бий. Эндээс холгүй төмөр зам байх бөгөөд олборлосон нүүрсийг Улаанбаатар хот руу тээвэрлэдэг.

2022 оны байдлаар тус дүүрэг нь 10510 өрх айлын 39579 хүн амтай, засаг захиргааны хувьд 8 хороотой 687,6 км² газар нутагтай. Үүний 43,6 %-ийг хөдөө аж ахуйн газар, 5,7 %-ийг суурин газар,

1,3 %-ийг дэд бүтцийн зам харилцаа, 1,8 %-ийг ойн сан, 0,01 %-ийг усан сан, 47,9 %-ийг улсын тусгай хэрэгцээний газар эзэлдэг ба 48 гаруй мянган малтай.

2022 оны 12-р сарын байдлаар Налайх дүүрэгт бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 261 байгууллага, боловсруулах үйлдвэрлэл эрхэлдэг 42 байгууллага, барилгын үйл ажиллагаа эрхэлдэг 35 байгууллага, боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг 32, тээвэр агуулахын чиглэлээр 26, төрийн захиргааны 27 байгууллага, бусад үйлчилгээний 39 байгууллага, нийт 596 байгууллага бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Налайх хотын хэрэгцээт техникийн болон ундны усыг Туул голоос татсан ус дамжуулах хоолойгоор бүрэн хангаж байгаа ба уурхайн хэрэгцээт бэхэлгээний модон материалыг төмөр замын тээврээр хангаж байжээ.

Зам харилцаа

Налайхын уурхай нь Улаанбаатар хотоос зүүн урагш Налайх дүүргийн нутагт оршино. Энд Налайх Улаанбаатарыг холбосон 45 км урт автозам болон төмөр зам бий. Налайхын уурхай нь Улаанбаатарын 4-р цахилгаан станцтай автозам болон төмөр замаар мөн холбогдсон. Налайх Улаанбаатарын автозам нь 2-р ангиллын автозам юм. Мөн уурхайн дотор 4-р ангиллын 900 метр урт зам бий. Мөн Монголын хойд урд хилийг холбосон гол төмөр зам Налайхын ойролцоо өнгөрнө. Иймээс Налайх нь зам харилцааны хувьд тохиромжтой байрлалд байгаа гэж хэлж болно.

Тус бүс нутгийн Налайх дүүрэгт орших элсний бүс нутгийн хүрээнд элс, хайрга олборлох уул уурхайн үйлдвэрүүд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд орон нутгийн оршин шуугчид голчлон гар аргаар хуучин ашиглагдсан уурхайн дээд хэсгийн орхигдсон хамгаалалтын цулын нүүрсийг бага гүнд налуу жижиг уурхайгаар ашиглаж байна. Улаанбаатар хот, Төв аймаг, Багануур дүүрэгтэй засмал болон шороон замаар жилийн аль ч улиралд явах боломжтой замаар холбогдсон, төмөр замын өртөөтэй олборлосон нүүрсээ шууд тээвэрлэх боломжтой дэд бүтэц дунд зэрэг хөгжсөн газар нутаг юм. Үүрэн холбоо харилцааны салбар нэгжүүд байрладаг. Интернетийн харилцаа холбоо сайн хөгжсөн газар нутаг юм. Уурхайн ажиллах үеийн цахилгаан эрчим хүчийг төвийн шугамаас авч хангана.

Цахилгаан хангамж

Налайхын уурхай нь Улаанбаатараас зүүн урагш 45км-ын зайд, Налайх дүүргээс 3км зайд оршино. Улаанбаатарын 4-р цахилгаан станц 540мвт-ын чадалтай бөгөөд эндээс Налайхын район дахь 110квт-ын шугам, дэд станцаар дамжуулан хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангана. 50км урттай, 2 хэлхээтэй LGJ-150 дамжуулах шугамаар цахилгааныг дамжуулах ба хүлээн авах трансформаторын чадал 50кВА болно (2х25000кВА). Нүүрсний уурхайн эрчим хүч хангамжийн үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг үндэслэн дэд станцыг салангид 2 эх үүсвэрээс цахилгаанаар хангах шийдлийг авч үзсэн юм.

Усны хангамж

Усны эх үүсвэрийг барилгын ажлын явцад үйлдвэрлэлийн болон нийгэм ахуйн зориулалтаар ашиглах ба усыг Туул голоос авна. Ус шүүрүүлэн соруулах газар нь уурхайгаас 7км гаруй хол зайтай байдаг. Усны чанарыг үнэлэхдээ “Нийгэм ахуйн болон ундны усны ариун цэврийн стандартыг” мөрдөнө. Голын усыг цэвэрлэсний дараа уурхай байгуулах явцад нийгэм ахуйн болон үйлдвэрлэлийн аль аль зориулалтаар нь ашиглаж болно. Уурхайн цэвэрлэсэн усыг үйлдвэрлэлийн ус байдлаар ашиглах ба ус цэвэрлэх байгууламж баригдсаны дараа худгийн усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болно.

Түүхий эд материал хангамж

Уурхайг барьж байгуулах ажилд хэрэглэгдэх материал түүхий эд болох тоосго, цемент, элс хайрга зэргийг Монголд олборлох, үйлдвэрлэх боломжтой. Харин төмөр хийцүүдийг гадаад орноос импортлох шаардлагатай байна.

Уурхайн ерөнхий байдал

Налайхын уурхай нь Улаанбаатар хотоос зүүн урагш 45 км-т, Налайх дүүргийн нутагт Налайх хотоос 3 км орчим зайд оршино. Уурхай нь зам харилцааны хувьд тохиромжтой нөхцөлд орших бөгөөд уурхайг Сүмбэр Худаг ХХК хариуцан ажиллах юм. Уурхайг анх 1922 онд байгуулж байсан бөгөөд 70 гаруй жилийн турш ажиллаж 1980 аад оны сүүлчээр үйл ажиллагаагаа зогсоосон юм. Уг уурхай Налайхын уурхайн районы баруун хэсэгт оршино. Уурхайн барилгын нэгжээс санал болгож, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас баталсан координатын дагуу уурхайн талбай нь 1,98 км урт, 1,33 км өргөн буюу 1,9982 км² талбайг эзэлнэ. Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас баталсан нөөц тооцох аргачлал, мөн уурхайг ажиллуулж буй компаниас гүйцэтгэсэн геологи хайгуулын тайлан дээр үндэслэсэн зураг төсөл тооцооны дагуу Налайхын уурхайн нүүрсний нөөц баялгийг 23,8717 сая тонн гэж үзэж байна.

Тус уурхай II, III, IV, V, VIII гэсэн олборлох боломж бүхий нүүрсний давхаргуудтай. VIII давхарга нь харьцангуй нимгэн бөгөөд дундаж зузаан нь 1,25 м бол бусад 4 давхарга дунд зэргийн зузаантай, дундаж зузаан нь 2,8 м болно. Нүүрсний давхаргууд 5°-аас 15° хэмийн уналтай. Уурхайн талбайд 3 хагарал эвдрэл байгаа бөгөөд хоорондын зай нь харьцангуй багавтар. Уурхай нь дунд зэргийн үнслэгтэй, хүхэр багатай, дэгдэмхий бодис ихтэй, нүүрсжилтийн зэрэг харьцангуй өндөртэй, харьцангуй өндөр илчлэгтэй хүрэн нүүрс олборлох бөгөөд үүнийг эрчим хүчний болон Налайх дүүргийн дулааны станц болон Төв аймгийн хэрэглэгчдийн хэрэгцээнд ашиглаж болно.

ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж, батлуулж байх шаардлагатай.

“Сүмбэр худаг” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ний дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Налайхын нүүрсний уурхайн баруун жигүүр” нэртэй Налайхын нүүрсний ордыг далд аргаар ашиглах төслийн үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ундны усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээ,
- Байгаль орчны төлөв байдалд хяналт тавих, хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөх,
- Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож, доор дурдсан ажлуудыг хэрэгжүүлэх.

4.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт №7. Сөрөг нөлөөллийг бууруулах, орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арилгах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн өртөг /мян.төг/ | Тоо хэмжээ | Нийт зардал /мян.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж |
|-----------------|--|---|-------------------------------------|-------------|-------------------------|------------|-----------------------|------------------------------|
| Агаарын орчин | | | | | | | | |
| 1 | Уурхайн малталт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: -Уурхайн малталт, хөрс хуулалт, овоолго зэрэг газар шорооны ажил, -Ажилчдын суурин болон уурхай байгуулах үеийн газар шорооны ажил | Уурхайн тэсэлгээний үед тоосжилт ихээр үүсэх үед услагаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах | Ажлын мөрөгцөг | | Дотоод төлөвлөлтөөр | | | 2024 он |
| Ус | | | | | | | | |
| 2 | Унд ахуйн уснаас ундны усны шинжилгээ өгөх | Шинжилгээний үр дүнг стандарттай харьцуулах | Гэрээгээр тохирсон худгийн ус | удаа | 50.0 | 1 | 50.0 | 2024 он |
| Хөрсөн бүрхэвч | | | | | | | | |
| 3 | Хөрсний үржил шим, бохирдлыг хэмжих | Шинжилгээний үр дүнг стандарттай харьцуулах | ТЗ талбай дахь 2 цэгээс 2 дээж авна | удаа | 33.0 | 4 | 132.0 | 2024 он |
| Ургамлан нөмрөг | | | | | | | | |
| 4 | Ургамлан нөмрөг устах, зүйлийн тоо буурах, бэлчээрийн хумигдах | Уурхай орчмын ургамлын мониторингийн судалгааг хийх | Уурхайн орчим | Удаа | 500.0 | 1 | 500.0 | 2024 он |
| Нийт | | | | | - | | 682.0 | |

4.1.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2024 онд нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа төлөвлөөгүй болно.

4.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжих орчны оршин суугчдын газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөхгүй, одоогийн байгаа ахуй амьжиргаанд эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй зардал тооцох шаардлагагүй болно.

4.1.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тусгай зөвшөөрлийн талбайд Налайхын уурхайчдын хөшөө болон 2ш хиргэсүүрийг Соёлын өвийн тухай болон хууль тогтоомжийн дагуу холбогдох мэргэжлийн байгууллага болон орон нутагтай хамтран шилжүүлэх эсэх, мөн дүгнэлтийн дагуу бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэхүү ажлын зардалд мэргэжлийн байгууллагаар судалгаа шинжилгээний тайлан бичүүлж, дүгнэлт гаргуулсаны үндсэн дээр тодорхой болох тул төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн үйл ажиллагааны зардлын хүрээнд хийх боломжтой. Энэхүү ажлыг 2025-2026 онд зохион байгуулна.

4.1.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тус ордод албан ёсоор өнөөг хүртэл олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй, гэвч нөөцийн хэсэгшил бүртгэгдээгүй талбайд Бичил уурхайн журмаар орон нутгийн иргэдийн ухсан далд уурхайн нэвтрэлтийн амууд тусгай зөвшөөрлийн талбайн зүүн хэсэгт олон байдаг.

2023 оны 11 сарын 10-ны өдрийн Налайх дүүргийн ЗДТГ-аас ирүүлсэн тоот албан бичигт 47°45'16.00"N 107°15'35.00"E координатад нээлттэй буй цооног дээр менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, уг төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлт хийн амыг таглах ажил хийх даалгавар ирсэн, мөн БОННУ-ний тайланд мөн энэхүү эвдэгдсэн хэсгийн нөхөн сэргээлтийг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийхээр тусгасан байгаа тул дээрх албан шаардлага бүхий амыг эхний ээлжинд таглан аюулгүй болгох ажлыг хийхээр төлөвлөв.


**НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Д.Даваажавын гудамж, 2 дугаар хороо,
Налайх дүүрэг, Улаанбаатар хот 12790
Утас: (976) 7023 2252, 7023 2204
Цахим шуудан: nadubgov@webmail.com
Цахим хуудас: www.nad.ub.gov.mn


2023.11.10 № 04/210Х
Танай _____ -ны № _____ -т

Шаардлага хүргүүлэх тухай

Танай байгууллагын ашигт малтмал ашиглалтын MV-000221 дугаар тусгай зөвшөөрөлтэй талбайн 47°45'16.00"N 107°15'35.00"E координатад байгаа цооног нь хүн мал амьтан унах, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй нөхцөл байдалтай байна.

Иймд нүх цооног үүссэн амуудыг нөхөн сэргээх ажлыг байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөнд тусган эрх бүхий төрийн захиргааны байгууллагаар батлуулан, төлөвлөгөөг бүрэн биелүүлж, шаардлагын дагуу хийгдсэн ажлын тайланг 2023 оны 12 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Хавсралт 4 хуудастай.



2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажлын албан шаардлага хүргүүлсэн бичиг



Зураг №6. Нөхөн сэргээлтийн хийх цооногийн амын зураг

Уг ам нь босоо хэлбэтэй, өмнө манай компаниас модоор хаалт хийн аюулгүй болгож байсан боловч орон нутгийн иргэд хаалтыг тонон амыг нээсэн байдалтай байна. Иймд хоосон орон зайг Налайхаас барилгын суурийн хөрс шороо зэргийг тээвэрлэн авчирч нөхөн дүүргэлт хийхээр төлөвлөв. Ашиглах тоног төхөөрөмжийг түрээсээр авч ажиллуулна.

Хүснэгт №8. Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ

| Амрын үзүүлэлт | нэгж | дүн |
|----------------|----------------|-------|
| диаметр | м | 1.50 |
| радиус | м | 0.75 |
| урт | м | 50.00 |
| Талбай | м ² | 1.77 |
| Эзлэхүүн | м ³ | 88.31 |

Хүснэгт №9. Нөхөн сэргээлтийн ажлын тооцоолол, зардлын хэмжээ

| Техникүүд | Гүйцэтгэх ажил, сийрэгжилт тооцсон Кс=1.2 | Техникийн бүтээл | Шаардлагатай техникийн тоо / рейсийн тоо | Түрээсийн төлбөр | Ажиллах цаг |
|-----------------------|---|--------------------------|--|------------------|-------------|
| Х.нэгж | м ³ | м ³ /цаг | ш | мян.төг | мото.цаг |
| Утгуурт ачигч | 212.0 | 200.00 | 1 | 1,000.0 | 1.2 |
| Автосамосвал | 106.0 | 16 м ³ / удаа | 1/7 | 1,500.0 | 12 |
| Бусад материал зардал | | | | 1,000.0 | |
| | 317.9 | | | 3,500.0 | |

4.1.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

| № | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал /мян.төг/ | Нийт зардал /мян.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|-------------|--|--|---------------------------|------------|--------------------------|------------------------|--------------------------------|---|
| 1 | Уурхайн удирдлагын авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх | Уурхайн удирдлага | 1 | Үйл ажиллагааны зардал | Үйл ажиллагааны зардал | 2024 он | -MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сатндартууд, Далд уурхайн аюулгүй ажиллаганы дүрэм |
| 2 | | Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах | Уурхайн удирдлага ажилчид | 1 | 1,150.0 | 1,150.0 | 2024 он | ХАБЭА-н тухай хууль |
| Нийт | | | | | | 1,150.0 | | |

4.1.7. Тэрбум мод аяны хүрээнд мод тарих

Налайх дүүргийн удирдлагатай ярилцсаны үндсэн дээр дүүргийн доторх зам дагуу 200ш мод тарьж дүүргийн ТҮК-д хүлээлгэн өгөхөөр болсон.

Үүнд нэг ш мод бутыг 15,000 төгрөгөөр худалдан авах, мөн суулгах ажлын хөлс 5,000 гэж тооцон нэгж мод суулгах ажлын зардлыг 20,000 төгрөг гэж үзвэл нийт 4,000.0 мян.төгрөгийн зардлыг төсөвлөв.

4.1.8. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт № 11. БОМТ-ий хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

| № | БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр | Мэдээний агуулга | Хугацааны тов |
|---|---|-------------------------------|--|---------------|
| 1 | Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р Хорооны иргэд, Налайх дүүргийн ЗДТГ | Уулзалт, санал асуулга | БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах | 10-11-р сар |

| | | | | |
|---|--|---------------------------------|---|-----------------------------------|
| 2 | Нийслэлийн БОАЖГ-г тайлангаа хүргүүлэх | Тайлангийн эх хувь, албан бичиг | Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх Дүгнүүлэх | 2024.11.01 2024.12.31 |
| 3 | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам | Тайлангаа баталгаажуулах | Тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтийн талаар | 2024-12 сараас 2025 оны 02 сар |

4.2. БОМТ-ний нийт зардал

“Сүмбэр худаг” ХХК нь 2024 оны БОМТ-г БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа. 2024 оны 09 сараас 12 сарын хооронд хэрэгжүүлэх БОМТ-нд 9.3 сая.төг төлөвлөлөө.

Хүснэгт № 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | 2024 он |
|----|---|----------------|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах, ОХШ-ний төлөвлөгөө | 682.0 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 3,500.0 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | |
| 5 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | |
| 6 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | |
| 7 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | |
| 8 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 1,150.0 |
| 9 | Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих /200ш | 4,000.0 |
| 10 | БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч | |
| | Нийт | 9,332.0 |

ДҮГНЭЛТ

“Сүмбэр худаг” ХХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Налайхын нүүрсний уурхайн баруун жигүүр” нэртэй Налайхын нүүрсний ордыг далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг хийж гүйцэтгэлээ.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлж тухайн онд хийсэн ажлаа холбогдох газруудаар хянуулж батлуулах шаардлагатай байгаа болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2024 онд нийт 9.3 сая.төг зарцуулахаар төлөвлөлөө.

“Сүмбэр худаг” ХХК нь нөхөн сэргээлтийн баталгааны дансанд 4,666.0 мян.төг байршуулсан.